

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан сумын Хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/06/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2022 он</p>	<p>Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг: <a href="mailto:munkhbayarsh@audit.gov.mn">munkhbayarsh@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: <a href="mailto:battsetsegs@audit.gov.mn">battsetsegs@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: У.Батсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: <a href="mailto:batsurenu@audit.gov.mn">batsurenu@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум, 14-н байр  
Утас: 7037-3080, факс: 9791-7037-3080  
E-mail: darhanuul@tuch.gov.mn

ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Т.ТУЛГАА ТАНАА

2020.02.10 № 66  
санал 2020.01.25 -ны № 01/69 -



**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Хөрөнгө оруулалтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/омчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан сумын Хөрөнгө оруулалтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагчид өггээдээс хараат бус, аудиторын ес зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүрдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛСАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009029021

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	33,637,559.00	-
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>33,637,559.00</b>	-
	Нийт өр төлбөрийн дүн	33,637,559.00	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	-
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>33,637,559.00</b>	-
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	162,942,100.00	246,362,441.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	162,942,100.00	246,362,441.00
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	-	-
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	-	-
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	-	-
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	-	-
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	252,942,100.00	280,000,000.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	637,559.00	67,338,185.00
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>252,304,541.00</b>	<b>212,661,815.00</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(252,304,541.00)</b>	<b>(212,661,815.00)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>387,000,000.00</b>	<b>212,661,815.00</b>
	Урсгал зардал		
	Хөрөнгийн зардал	387,000,000.00	212,661,815.00
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>387,000,000.00</b>	<b>212,661,815.00</b>
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	387,000,000.00	212,661,815.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан сумын Хөрөнгө оруулалт нь иргэдийг эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, орон нутагт шаардлагатай хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан авто зам засвар, шинэчлэлт, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, төрийн байгууллагын тоног төхөөрөмж, материаллаг баазыг нэмэгдүүлэх зэрэг төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байна.

### Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан сумын хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

## **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай, тендер сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулахдаа мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасантай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

### **Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 278.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны дүнг 160.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг залруулж, 118.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө. Үүнд:

#### **1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Хөрөнгө оруулалтын зардлаас тамирчдын бэлтгэх хийх, хувцас солих, ариун цэврийн өрөөнүүдийн урсгал засварт 13.0 сая, DVD цомог гаргахад 5.0 сая, МА3 машины хогны шүүр худалдан авахад 9.0 сая, нийт 27.0 сая төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн байна. Мөн 2020 оны эцэст нэмж баталснаас хийгдээгүй 4.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг тайлант онд шилжих хөрөнгө оруулалтаар баталсан бөгөөд тодотголоор төсөл арга хэмжээний нэр, байршлыг өөрчлөн баталсан.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

- Хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж батлуулахдаа Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал, заавар”-ыг баримтлах
- Дараагийн төсвийн жилд шилжүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйл, 43 дугаар зүйлийн 43.6 дахь заалтын дагуу зохион байгуулах

#### **2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

“Хог тээврийн авто машин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулахдаа хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасан бүрэлдэхүүнийг оролцуулаагүй.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

- Тендер сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасан бүрэлдэхүүнийг оролцуулан томилж байх

#### **3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### **3.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан мэдээллийг 1, 5 сард, 6.1.6, 6.3.6, 6.3.7, 6.4.1-д заасан мэдээллүүдийг 5 сард, 6.4.4-т заасан мэдээллийг 3, 5, 11 сард тус тус хугацаа хоцроож мэдээлсэн. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т заасан 87.4 сая төгрөгийн 2 мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулаагүй.

##### **3.2. Өгсөн зөвлөмж:**

- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх

## 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

## 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ										
2	Төсөл, хөтөлбөр	5	278.7	1	160.3	-	-	-	-	4	118.4
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	<b>НИЙТ</b>	<b>5</b>	<b>278.7</b>	<b>1</b>	<b>160.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>118.4</b>